



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2025/005/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn
Даланзадгад хот
2024 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn
Аудитор: Э.Жаргал
Утас: 70533552 Цахим хаяг: jargale@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.03.25 № 297

танай _____ -ны № _____ -т

ХАНБОГД СУМЫН ЗАСАГ ДАРГА
М.ЦЭВЭЭНРАВДАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Орон нутгийн нөөц сангаас 231,667.4 мянган төгрөг зориулалт бусаар, тайлант онд хэрэгжүүлсэн 12 арга хэмжээг журам, төлөвлөгөө, хөтөлбөр, төсвийн тооцоололгүйгээр зарцуулсан, арга хэмжээний зардлаас 177,727.8 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, 459,475.2 мянган төгрөгөөр контент видео нэвтрүүлэг, гарын бэлэг худалдан авахад, анхан шатны баримтын бүрдэлгүй 60,000.0 мянган төгрөг зарцуулсан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16, 4.1.17, 4.1.24, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 24 дугаар зүйлийн 24.7, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.4, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2, 3.1.4, 3.1.5, 6.1.6.5, 7.1-д заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Бичиг хэрэг СЭЗБЭН/СТАН 4625021600

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 27,794,944.6 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий дулааны станц барих гэрээг байгуулан гүйцэтгэлээр 23,657,047.1 мянган төгрөг буюу 80 хувийн санхүүжилт олгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Цагаанхад суурьшлын бүсэд төрийн үйлчилгээний нэг цэгийн үйл ажиллагааг сар бүр зохион байгуулж хэвшсэн байна.

Бусад асуудал

Тайлант онд хүү торгуулийн тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулан орлогын төлөвлөгөөг 54,414.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	73,730,309.78	146,029,241.54
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	67,035,109.27	93,484,078.12
311	Кассад байгаа бэлэн мөнгө	70.16	377.10
31110	Төгрөг	70.16	377.10
312	Банканд байгаа бэлэн мөнгө	67,035,039.11	93,483,701.02
3121	Төгрөг	67,035,039.11	93,483,701.02
31211	Төрийн сангийн харилцах	66,505,746.63	92,331,999.27
31213	Арилжааны банк дахь харилцах	529,292.48	1,151,701.75
33	АВЛАГА	779,132.10	734,996.94
33400	Зээлийн хүүгийн авлага	21,845.39	20,720.08
33401	Дансны авлага /ТӨҮГ/	318,874.29	288,654.29
335	Бусад авлага	438,412.42	425,922.58
3351	Байгууллагаас авах авлага	249,645.55	259,699.05
3352	Хувь хүмүүсээс авах авлага	188,766.87	166,233.53
34	УРЬДЧИЛГАА	-	42,590.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	42,590.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,632,592.82	1,712,611.68
351	Түүхий эд материал	860,969.24	1,047,480.86
35110	Тусгай зориулалттай материал	793,521.03	1,032,447.81
35130	Эм боох материал	67,448.21	15,033.04
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	19,580.00	19,580.00
354	Хангамжийн материал	752,043.58	645,550.82
35410	Бичиг хэргийн материал	7,398.79	7,261.98
35420	Аж ахуйн материал	79,383.54	213,377.17
35430	Сэлбэг хэрэгсэл	58,426.92	45,412.10
35440	Түлш, шатах тослох материал	5,335.36	3,460.00
35450	Барилгын засварын материал	22,861.08	25,044.12
35460	Хүнсний материал	10,789.27	10,789.27
35470	Бусад хангамжийн материал	567,848.62	340,206.18
36	НӨӨЦИЙН БАРАА	4,283,475.59	50,054,964.80
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	4,283,475.59	50,054,964.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	51,391,095.35	75,019,038.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	51,391,095.35	75,019,038.45
392	Биет хөрөнгө	45,180,259.90	68,810,402.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	25,478,954.13	32,522,005.97
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,650,382.26)	(3,733,111.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,714,667.65	4,266,387.99
39204	Хуримтлагдсан элэгдэл	(871,172.47)	(1,274,728.23)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,026,618.12	4,579,591.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(621,747.81)	(1,043,349.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	303,610.43	340,150.21
39208	Хуримтлагдсан элэгдэл	(147,567.88)	(186,777.53)
39209	Зам, гүүрний байгууламж	1,588,277.21	1,588,277.21
39210	Хуримтлагдсан элэгдэл	(145,592.08)	(225,005.94)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,010,833.35	36,562,508.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,526,223.07)	(4,605,529.87)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	19,984.57	19,984.57
393	Биет бус хөрөнгө	6,210,835.45	6,208,635.88
39301	Программ хангамж	25,620.18	26,940.18
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,639.23)	(13,158.80)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,194,854.50	6,194,854.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	125,121,405.12	221,048,279.99
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,778,657.80	12,884,485.45
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,162,577.67	1,645,160.66
413	Өглөг	871,933.38	1,354,516.38
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	115.80
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	291,187.40
4136	Бусад өглөг	871,933.38	1,063,213.18
41361	Байгууллагад төлөх өглөг	766,386.39	997,774.73
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	7,400.00	7,400.00

41363	Татварын өглөг /ТӨҮГ/	94,331.04	51,908.16
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	52.23	-
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	3,763.73	6,130.29
414	Урьдчилж орсон орлого	290,644.29	290,644.29
41440	Бусад урьдчилж орсон орлого	290,644.29	290,644.29
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,616,080.13	11,239,324.79
421	Урт хугацаат үнэт цаас	9,616,080.13	11,239,324.79
4211	Төгрөг	9,616,080.13	11,239,324.79
42229	Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	9,616,080.13	11,239,324.79
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	114,342,747.33	208,163,794.54
51	Засгийн газрын хувь оролцоо	114,342,747.33	208,163,794.54
511	Засгийн газрын оруулсан капитал орон нутгийн сан	7,828,055.30	4,728,347.44
51101	Өмч: - төрийн	7,828,055.30	4,728,347.44
51104	Өмч/төрийн/ ТӨҮГ	1,588,427.53	5,390,350.05
512	Хуримтлагдсан үр дүн	104,314,204.74	197,433,037.29
51210	Өмнөх үеийн үр дүн	40,754,729.95	104,333,493.25
51220	Тайлант үеийн үр дүн	63,559,474.78	93,099,544.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	612,059.76	612,059.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	125,121,405.12	221,048,279.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	416,497,376.57	314,123,806.99
11	ТАТВАРЫН ОРЛОГО	265,952,053.16	289,076,032.12
110	Орлогын албан татвар	111,301,519.23	107,330,844.97
1100	Хувь хүний орлогын албан татвар	111,601,510.84	107,680,844.97
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	110,399,413.05	105,626,402.21
110002	Үйл ажиллагааны орлого	1,034,859.46	145,193.31
110003	Хөрөнгийн орлого	-	254,414.01
110004	Хөрөнгө борлуулсны орлого	140,401.54	145,873.62
110008	Шууд бус орлого	26,836.78	1,508,961.82
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(299,991.60)	(350,000.00)
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(299,991.60)	(350,000.00)
113	Хөрөнгийн албан татвар	149,450,234.97	176,764,896.92
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	149,239,543.15	176,632,217.19
113002	Бууны албан татвар	4,382.00	5,783.00
113004	Малд ногдуулах албан татвар	116,309.82	126,896.73
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,200,298.95	4,980,290.23
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,198,595.34	1,027,184.10
118001	Улсын тэмдэгтийн хураамж	172,513.37	151,753.12
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	975,946.67	831,330.98
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	50,135.30	44,100.00
1181	Газрын төлбөр	3,902,599.72	3,895,352.44
118101	Газрын төлбөр	3,902,599.72	3,895,352.44
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	99,103.89	57,753.69
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	92,381.73	52,996.25
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	6,722.15	4,757.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,782,321.84	20,386,784.50
120	Нийтлэг татварын бус орлого	6,782,321.84	20,386,784.50
120002	Хүүгийн орлого	194,170.95	4,625.73
120003	Торгуулийн орлого	689,634.13	3,265,612.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	77,613.25	92,410.95
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,824.88	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	68,788.37	92,410.95
120009	Бусад орлого	1,001,096.46	1,386,325.24
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	2,869,375.32	4,884,449.73

120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	1,726,128.77	2,292,559.58
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө	3,520,774.19	12,549,996.85
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	155,786.32	495,922.91
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	143,763,001.57	4,660,990.37
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,458,908.80	4,000,351.79
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	2,458,908.80	4,000,351.79
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	658,781.52	660,638.58
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,500.00	2,700.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	593,332.87	345,108.40
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,962.27	14,805.90
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,986.38	298,024.29
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	140,645,311.25	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	79,179,918.52	-
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	61,465,392.73	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	352,777,256.79	220,897,037.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	352,777,256.79	220,897,037.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,071,189.33	21,911,058.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	610,689.83	1,053,448.61
210101	Үндсэн цалин	345,128.16	529,208.64
210102	Нэмэгдэл	244,552.70	434,312.44
210104	Урамшуулал	21,008.96	89,927.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,228.46	133,561.66
210201	Тэтгэврийн даатгал	52,700.69	90,593.50
210202	Тэтгэмжийн даатгал	6,216.48	10,952.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,899.09	8,503.76
210204	Ажилгүйдлийн даатгал	995.27	2,584.71
210205	Эрүүл мэндийн даатгал	12,416.92	20,926.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	188,954.14	1,815,138.76
210301	Гэрэл, цахилгаан	151,498.86	261,330.80
210302	Түлш, халаалт	35,220.24	1,454,549.55
210303	Цэвэр, бохир ус	2,235.05	99,258.41
2104	Хангамж, бараа материалын зардал	6,089,610.51	7,689,696.75
210401	Бичиг хэрэг	10,550.00	12,202.33
210402	Тээвэр, шатахуун	88,798.65	114,491.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,081.95	14,486.64
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	35,901.00	36,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	733,713.39	10,793.20
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	5,208,565.52	7,497,460.59
210410	Бараа материал шилжүүлсний зардал	-	4,261.79
2105	Норматив зардал	178.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	178.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,759.91	75,948.93
210601	Багаж, техник, хэрэгсэл	724.00	-
210604	Урсгал засвар	20,035.91	75,948.93
2107	Томилолт, зочны зардал	10,776.00	27,040.00
210702	Дотоод албан томилолт	10,776.00	27,040.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,102,739.56	7,633,090.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,474,878.69	5,756,296.75
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	150.79	667.57
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	579,973.03	469,910.48
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	-	84.70

210813	Бусад зардал /ТӨҮГ/	30,189.52	1,333,521.55
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	17,547.53	72,609.44
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,970,252.93	3,483,133.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,102,991.47	325,644.27
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,800.00	12,843.51
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,857,461.46	3,144,645.78
212	ТАТААС	30,000.00	30,000.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	30,000.00	30,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	30,000.00	30,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	338,676,067.46	198,955,979.08
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	197,890,879.69	198,754,022.84
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	197,890,879.69	198,754,022.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	130,896.21	115,801.41
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	45,661.11
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	130,896.21	70,140.30
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	140,654,291.56	86,154.84
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	79,179,918.52	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,465,392.73	-
213404	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	8,980.31	86,154.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	63,720,119.78	93,226,769.14
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	160,645.00	127,225.11
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	160,645.00	127,225.11
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	63,559,474.78	93,099,544.03

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,174,927.23	612,059.76	40,834,237.03	49,621,224.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,241,555.60	-	(79,507.07)	1,162,048.52
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,416,482.83	612,059.76	40,754,729.95	50,783,272.54
Тайлант үеийн үр дүн	-	-	63,559,474.78	63,559,474.78
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,416,482.83	612,059.76	104,314,204.74	114,342,747.33
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,416,482.83	612,059.76	104,314,204.74	114,342,747.33
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	702,214.66	-	19,288.52	721,503.18
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,118,697.49	612,059.76	104,333,493.25	115,064,250.51
Тайлант үеийн үр дүн	-	-	93,099,544.03	93,099,544.03
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,118,697.49	612,059.76	197,433,037.29	208,163,794.54

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	414,306,517.93	303,399,395.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	265,952,053.16	289,076,032.12
110	Орлогын албан татвар	111,301,519.23	107,330,844.97
1100	Хувь хүний орлогын албан татвар	111,601,510.84	107,680,844.97
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	110,399,413.05	105,626,402.21
110002	Үйл ажиллагааны орлого	1,034,859.46	145,193.31

110003	Хөрөнгийн орлого	-	254,414.01
110004	Хөрөнгө борлуулсны орлого	140,401.54	145,873.62
110008	Шууд бус орлого	26,836.78	1,508,961.82
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(299,991.60)	(350,000.00)
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(299,991.60)	(350,000.00)
113	Хөрөнгийн албан татвар	149,450,234.97	176,764,896.92
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	149,329,543.15	176,632,217.19
113002	Бууны албан татвар	4,328.20	5,783.00
113003	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	116,309.82	126,896.73
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,200,298.95	4,980,290.23
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,198,595.34	1,027,184.10
118001	Улсын тэмдэгтийн хураамж	172,513.37	151,753.12
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	975,946.67	831,330.98
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	50,135.30	44,100.00
1181	Газрын төлбөр	3,902,599.72	3,895,352.44
118101	Газрын төлбөр	3,902,599.72	3,895,352.44
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	99,103.89	57,753.69
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	92,381.73	52,996.25
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	6,722.15	4,757.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,591,463.20	9,665,073.31
120	Нийтлэг татварын бус орлого	4,591,463.20	9,665,073.31
120002	Хүүгийн орлого	193,900.05	-
120003	Торгуулийн орлого	689,634.12	326,612.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	132,797.65	144,046.82
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	132,797.65	144,046.82
120009	Бусад орлого	551,174.24	722,825.49
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	3,023,957.15	5,532,588.34
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	143,763,001.57	4,658,290.37
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,458,908.80	4,000,351.79
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	2,458,908.80	4,000,351.79
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	658,781.52	657,938.58
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,500.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	593,332.87	345,108.40
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,962.27	14,805.90
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,986.38	298,024.29
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	140,645,311.25	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	79,179,918.52	-
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	61,465,392.73	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	346,631,145.91	216,982,409.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	346,631,145.91	216,982,409.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,925,078.46	14,031,380.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,469,030.82	2,460,865.63
210101	Үндсэн цалин	345,133.34	531,982.47
210102	Нэмэгдэл	243,226.82	456,234.31
210104	Урамшуулал	21,266.76	89,927.54
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	859,403.89	1,382,721.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	312,462.63	516,462.31
210201	Тэтгэврийн даатгал	52,700.69	93,390.38
210202	Тэтгэмжийн даатгал	6,179.66	10,952.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,899.09	8,503.76
210204	Ажилгүйдлийн даатгал	995.27	2,584.71
210205	Эрүүл мэндийн даатгал	12,416.92	20,926.86
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	235,271.00	380,103.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	326,496.03	2,283,999.29
210301	Гэрэл, цахилгаан	151,498.86	266,907.50
210302	Түлш, халаалт	35,220.24	1,486,311.18
210303	Цэвэр, бохир ус	2,235.05	102,584.81
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	134,541.88	412,195.80
2104	Хангамж, бараа материалын зардал	1,273,772.82	2,001,696.93
210401	Бичиг хэрэг	10,550.00	12,203.33
210402	Тээвэр, шатахуун	88,798.65	114,491.20

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,081.95	14,486.64
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	35,901.00	36,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,118.70	11,309.70
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	429,016.94	533,714.09
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	686,305.59	1,279,491.96
2105	Норматив зардал	178.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	178.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,259.91	78,900.58
210601	Багаж, техник, хэрэгсэл	724.00	-
210604	Урсгал засвар	21,535.91	78,900.58
2107	Томилолт, зочны зардал	10,776.00	27,040.00
210702	Дотоод албан томилолт	10,776.00	27,040.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,143,519.78	6,106,232.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,741,318.00	5,478,324.63
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	81.60	4,143.65
210815	Хүүгийн төлбөрт төлсөн /ТӨҮГ/	150.79	1,130.29
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	382,698.08	589,790.06
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	713.70	1,165.50
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	18,557.60	31,678.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,366,582.47	556,183.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,356,782.47	543,339.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,800.00	12,843.51
212	ТАТААС	30,000.00	30,000.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	30,000.00	30,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	30,000.00	30,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	338,676,067.46	202,921,029.08
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	197,890,789.69	202,719,072.84
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	197,890,879.69	202,719,072.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	130,896.21	115,801.41
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	45,661.11
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	130,896.21	70,140.30
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	140,654,291.56	86,154.84
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	79,179,918.52	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,465,392.73	-
213404	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	8,980.31	86,154.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	67,675,372.02	86,416,986.26
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	521.92	5,544.66
140007	Хүлээн авсан хүүний орлого	521.92	5,544.66
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,379,251.21	59,973,562.08
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,379,251.21	59,973,562.08
2200	Дотоод эх үүсвэрээр	13,379,251.21	59,973,562.08
223001	Бусад хөрөнгө	8,288,171.28	49,258,907.71
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,091,079.93	10,714,654.37
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(13,378,729.30)	(59,968,017.42)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	54,296,642.72	26,448,968.85
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,738,466.55	67,035,109.27
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	67,035,109.27	93,484,078.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	124,417,646.80	72,821,762.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,760,420.40	13,300,080.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,510,288.40	8,545,252.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,073,988.50	990,380.15

210101	Үндсэн цалин	562,760.10	531,982.47
210102	Нэмэгдэл	503,978.40	456,234.31
210104	Урамшуулал	7,250.00	2,163.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,102.30	126,523.29
210201	Тэтгэврийн даатгал	94,384.60	86,804.99
210202	Тэтгэмжийн даатгал	10,711.90	10,132.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,569.50	6,884.44
210204	Ажилгүйдлийн даатгал	4,012.50	2,223.03
210205	Эрүүл мэндийн даатгал	21,423.80	20,478.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,118,026.60	1,855,803.49
210301	Гэрэл, цахилгаан	386,648.00	266,907.50
210302	Түлш, халаалт	1,577,837.50	1,486,311.18
210303	Цэвэр, бохир ус	153,541.10	102,584.81
2104	Хангамж, бараа материалын зардал	192,092.30	183,234.98
210401	Бичиг хэрэг	12,300.00	12,203.33
210402	Тээвэр, шатахуун	109,400.00	109,235.31
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,192.30	14,486.64
210404	Ном, хэвлэл	900.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	36,000.00	36,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,300.00	11,309.70
2105	Норматив зардал	350.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	350.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	111,700.00	92,396.13
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,000.00	13,495.55
210604	Урсгал засвар	97,700.00	78,900.58
2107	Томилот, зочны зардал	27,324.90	26,190.00
210702	Дотоод албан томилот	27,324.90	26,190.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,535,011.60	5,136,296.61
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,535,011.60	5,136,296.61
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	312,692.20	134,428.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	299,692.20	121,584.55
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,000.00	12,843.51
212	ТАТААС	30,000.00	30,000.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	30,000.00	30,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	30,000.00	30,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,220,132.00	4,724,827.94
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	5,146,151.80	4,655,349.64
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	5,146,151.80	4,655,349.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,980.20	69,478.31
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,680.20	45,661.11
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,300.00	23,817.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	108,657,226.40	59,521,682.06
223001	Бусад хөрөнгө	108,657,226.40	59,521,682.06
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	124,417,646.80	72,330,363.65
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,181,406.70	4,000,351.79
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	4,181,406.70	4,000,351.79
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	119,289,899.20	68,185,965.05
132001	Орон нутгийн төсвөөс	119,289,899.20	68,185,965.05
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	946,340.90	144,046.82
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	78,000.00	144,046.82
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	868,340.90	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	868,340.97

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	376,941.92
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	79.00	79.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3.00	3.00
610001	Төсвийн байгууллага	3.00	3.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	38.00	38.00
620001	Удирдах ажилтан	9.00	9.00
620002	Гүйцэтгэх ажилтан	25.00	25.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	658,781.52	657,938.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	286,406.46	657,938.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	162,239.94	525,460.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	87,764.17
210104	Урамшуулал	-	87,764.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	9,835.24
210201	Тэтгэврийн даатгал	-	6,585.39
210202	Тэтгэмжийн даатгал	-	820.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,619.32
210204	Ажилгүйдлийн даатгал	-	361.68
210205	Эрүүл мэндийн даатгал	-	448.30
2104	Хангамж, бараа материалын зардал	6,232.72	5,255.90
210401	Бичиг хэрэг	-	5,255.90
210402	Тээвэр, шатахуун	6,232.72	-
2107	Томилолт, зочны зардал	868.00	850.00
210702	Дотоод албан томилолт	868.00	850.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	155,139.22	421,755.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	155,139.22	421,755.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	124,166.52	132,477.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,186.21	46,323.10
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	115,186.21	46,323.10
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,980.31	86,154.84
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	8,980.31	86,154.84
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	372,375.06	-
2200	Дотоод эх үүсвэрээр	372,375.06	-
223001	Бусад хөрөнгө	372,375.06	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	658,781.52	657,938.58
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	658,781.52	657,938.58
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,500.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	593,332.87	345,108.40
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,962.27	14,805.90
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,986.38	298,024.29
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 970.3 сая төгрөгийн 15 зөрчил¹ илэрснээс, 0.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 969.9 сая төгрөгийн 10 зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Тайлант онд орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас 0.4 сая төгрөгийн урлагийн хувцас худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байгаад Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу төлбөрийн акт тогтоож ажиллав.

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Сумын Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зардлаас 200.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.2-д "урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт 2: Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас уралдаан тэмцээн зохион байгуулахад зориулан 25.1 сая төгрөг олгож төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2-д "Энэ журмын 1.1 заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно", 6.5-д " нөөц хөрөнгийн зарцуулалтад санхүү, төрийн сангийн нэгж, төсвийн захирагч тус хяналт тавина", 7.1-д "төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Илрүүлэлт 3: Тайлант онд 6.2 сая төгрөгийг шинэ жилийн арга хэмжээнд зориулан зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 24 дугаар зүйлийн 24.7-д "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно", 3 дугаар зүйлийн 3.1.2-д "урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт 4: Тайлант онд арга хэмжээний зардлаас 177.8 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д "хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг", 4.1.17-д "арга хэмжээ" гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт 5: Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тусламж дэмжлэг үзүүлэх, Чадварлаг мэргэжилтнүүдийг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд орон нутгаас дэмжих зардлаас анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар 60.0 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5"хариуцлагатай байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт 6: "Хөгжлийн гүүр"хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчдыг БНСУ-д туршлага судлуулсан ч гаднын орны туршлагаас орон нутагт нэвтрүүлсэн, шинэ санал санаачилга гаргаагүй төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт 7: Тайлант онд арга хэмжээний зардлаас 100 жилийн түүхэн ном бүтээхэд зориулан 139.3 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь УСНБББОУС-1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.3-д "хэвлэлийн захиалгын төлбөр", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт 8: Арга хэмжээний зардлаас контент, видео нэвтрүүлэг бэлтгэхэд 100.0 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь УСНБББОУС-1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.4-д "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт 9: Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхдээ 9.5 сая төгрөгийн дэмжлэгийг 3 албан хаагчид давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5"хариуцлагатай байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно",15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт 10: Тайлант хугацаанд төсөл, арга хэмжээний зардлаас 210.2 сая төгрөгийн гарын бэлэг, дурсгалын зүйлс худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.7-д "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1: Тайлант онд малын тоо толгойн албан татвар, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр , Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар, Хөрөнгө борлуулсны орлогын албан татварыг 34,754.1 сая төгрөг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн орлогыг бүрдүүлэх талаар ажил зохион байгуулан төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлэн ажиллах,

Илрүүлэлт 2: Сумын ИТХ-ын 2024 оны 19/02 тоот тогтоолоор 48 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан боловч 12 төсөл, арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар боловсруулсан журам, төлөвлөгөө, хөтөлбөр, төсвийн тооцоололгүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-д "Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэл, санхүүгийн эх үүсвэр, хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, хариуцах байгууллагыг тусгана", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5-д"хариуцлагатай байх", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжүүлэх журам, төлөвлөгөөг батлуулан мөрдөж ажиллах.

Илрүүлэлт 3: Тайлант онд хэрэгжүүлсэн арга хэмжээний зардлаас 265.7 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17-д "арга хэмжээ" гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар

төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлэхээс илүүтэй материаллаг баазыг хөгжүүлэх ирээдүйд үр өгөөжөө өгөх бодитой арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.

Илрүүлэлт 4 : Албан байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэн дэмжлэг олгохдоо уг байгууллагын дансаар дамжуулахгүй өөр аж ахуйн нэгж байгууллагад шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5"хариуцлагатай байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн санхүүгийн ажил гүйлгээ, анхан шатны баримт үнэн зөв байх, бодитой байхад анхаарч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл асуудал

/сая төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сумын Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зардлаас 200.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн	1	200.3				200.3						
2	Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас уралдаан тэмцээн зохион байгуулахад зориулан 25.1 сая төгрөг олгож төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	25.1			1	25.1						
3	Тайлант онд 6.2 сая төгрөгийг шинэ жилийн арга хэмжээнд зориулан зарцуулсан байна	1	6.2				6.2						
4	Тайлант онд арга хэмжээний зардлаас 177.7 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулсан байна	1	177.8				177.8						
5	Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тусламж дэмжлэг үзүүлэх, Чадварлаг мэргэжилтнүүдийг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд орон нутгаас дэмжих зардлаас анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар 60.0 сая төгрөг зарцуулсан байна.	1	60.0			1	60.0						
6	"Хөгжлийн гүүр"хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчдыг БНСУ-д туршлага судлуулсан ч гаднын орны туршлагаас орон нутагт нэвтрүүлсэн,	1	41.4				41.4						

	шинэ санал санаачилга гаргаагүй төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.											
7	Албан байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэн дэмжлэг олгохдоо уг байгууллагын дансаар дамжуулахгүй өөр аж ахуйн нэгж байгууллагад шилжүүлсэн байна.	1					1	-				
8	Сумын ИТХ-ын 2024 оны 19/02 тоот тогтоолоор 48 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан боловч 12 төсөл, арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар боловсруулсан журам, төлөвлөгөө, хөтөлбөр, төсвийн тооцоололгүйгээр зарцуулсан.	1					1	-				
9	Тайлант онд хэрэгжүүлсэн арга хэмжээний зардлаас 265.7 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг олгосон байна.	1					1	-				
10	Тайлант онд малын тоо толгойн албан татвар, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар, Хөрөнгө борлуулсны орлогын албан татварыг 34,754.1 сая төгрөг дутуу төвлөрүүлсэн.	1					1	-				
	Дүн	10	510.8	0	-	2	510.8	4	-			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант онд арга хэмжээний зардлаас 100 жилийн түүхэн ном бүтээхэд зориулан 139.3 сая төгрөг зарцуулсан байна.	1	139.3				139.3		
2	Арга хэмжээний зардлаас контент, видео нэвтрүүлэг бэлтгэхэд 100.0 сая төгрөг зарцуулсан	1	100.0			1	100.0		
3	Тайлант хугацаанд төсөл, арга хэмжээний зардлаас 210.2 сая төгрөгийн гарын бэлэг, дурсгалын зүйлс худалдан авсан байна.	1	210.3				210.3		-
4	Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхдээ 9.5 сая төгрөгийн дэмжлэгийг 3 албан хаагчид давхардуулан олгосон байна	1	9.5			1	9.5		
5	Тайлант онд орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас 0.4 сая төгрөгийн урлагийн хувцас худалдан авсан.	1	0.4	1	0.4				
	Дүн	5	459.5	1	0.4	2	459.1		-